

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуульд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/151 дүгээр зүйлийн 151.11 дэх хэсэг:

“151.11.Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх /сервитут/-ийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.”

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 152 дугаар зүйлийн 152.1 дэх хэсгийн “...бусдын эд хөрөнгийг хязгаартай эзэмшиж, ашиглах эрхийг узуфрукт гэнэ.” гэсний дараа “Үл хөдлөх эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэж нэмсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг